

БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

### НАМ, НЭР ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН САНХҮҮЖИЛТ, ТҮҮНИЙ ЗАРЦУУЛАЛТ, ГҮЙЦЭТГЭЛД ДҮГНЭЛТ ГАРГАХ, НИЙТЭД МЭДЭЭЛЭХ

АУДИТЫН КОД: БУА-2020/08/-НА

БУЛГАН ХОТ 2020 ОН

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын  
Дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр  
Утас: 70342580      Цахим хаяг:  
Аудитын менежер Ж.Энхцоодол  
Утас: 70342716      Цахим хаяг:  
Ахлах аудитор Г.Намчинсүрэн  
Утас: 70342716      Цахим хаяг:  
Аудитор              З.Ганбаатар

Энэхүү аудитын тайлантай холбоотой  
мэдээллийг дараах хаягаар авна уу.  
Цахим хуудас [www.audit.mn](http://www.audit.mn)



БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2020 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 2/36

Булган

Нийцлийн аудитын тайлан  
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2 заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаал, 2016 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан "Нийцлийн аудитын түр журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалт, 2018 оны А/221 дүгээр тушаалаар баталсан "Аудитын чанарын хяналтын журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Ерөнхий аудиторын "Нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний зарцуулалт, гүйцэтгэлд дүгнэлт гаргах, нийтэд мэдээлэх" сэдэвт нийцлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитаар илэрсэн зөрчлийг Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 2.3-д заасны дагуу холбогдох байгууллагад хүргүүлж ажиллахыг аудитын менежер /Ж.Энхцоодол/-д даалгасугай.

3. Аудиттай холбоотой ажлын болон нотлох баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, аудитын тайланг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтэд түгээхийг Нийцлийн аудитын албаны ахлах аудитор /Г.Намчинсүрэн/-т үүрэг болгосугай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.НАМЧИНСҮРЭН ДАНХБАЯР

## АГУУЛГА

---

Товчилсон үгийн тайлбар.....	3
Хүснэгт, дүрслэл, хавсралтын товъёог.....	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудитын бүрэлдэхүүн, хугацааны мэдэгдэл.....	5
БҮЛЭГ 1. Аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуулийн зардлын дансны мэдээллийг 1 нам, 28 нэр дэвшигч, сонгуулийн зардлын тайланг МАХН-ын аймгийн 1, сумын 5, МАН- ын сумын 7, АН-ын сумын 15 нам болон нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй байна.....	6
БҮЛЭГ 2. Хуулиар зөвшөөрөгдөөгүй 9973.5 мянган төгрөгийн хандивыг 41 нэр дэвшигч, 8.0 сая төгрөгийн хандивыг 1 нам зарцуулсан байна.....	6-9
ДҮГНЭЛТ.....	9-10

## ХАВСРАЛТУУД

**Товчилсон үгийн тайлбар**

<b>АДБОУС</b>	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
<b>ҮАГ</b>	Үндэсний Аудитын газар
<b>МУЕА</b>	Монгол Улсын Ерөнхий Аудитор
<b>ТАБ</b>	Төрийн аудитын байгууллага
<b>ИТХ</b>	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
<b>НА</b>	Нийцлийн аудит
<b>АНСДИТХСТ</b>	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн сонгуулийн тухай
<b>МАН</b>	Монгол ардын нам
<b>АН</b>	Ардчилсан нам
<b>МАХН</b>	Монгол ардын хувьсгалт нам

## Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймаг, сумын ИТХ-ын ээлжит сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, нэр дэвшигчийн тоо	6
Хүснэгт 2	Намын сонгуулийн зардлын санхүүжилт, мянган төгрөг	7
Хүснэгт 3	Нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, мянган төгрөг	7
Хүснэгт 4	Намын сонгуулийн зардлын ангилал	8
Хүснэгт 5	Нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын ангилал	8
Хүснэгт 6	Нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын хэмжээ	9

## Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Аймаг, сумын Орон нутгийн ИТХ-ын ээлжит 2020 оны сонгуулийн намын сонгуулийн зардлын санхүүжилт	
Хавсралт 2	Аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуулийн намын сонгуулийн зардлын зарцуулалт	
Хавсралт 3	Аймаг, сумын Орон нутгийн ИТХ-ын ээлжит 2020 оны сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын санхүүжилт	
Хавсралт 4	Аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын зарцуулалт	
Хавсралт 5	Аймаг, сумын ИТХ-ын ээлжит сонгуульд оролцсон намын сонгуулийн зардлын дансны мэдээлэл, сонгуулийн зардлын тайланг хувийн аудитаар баталгаажуулан Төрийн аудитын байгууллагад хүргүүлсэн судалгаа	
Хавсралт 6	Аймаг, сумын ИТХ-ын ээлжит сонгуульд оролцсон нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансны мэдээлэл, сонгуулийн зардлын тайланг хувийн аудитаар баталгаажуулан Төрийн аудитын байгууллагад хүргүүлсэн судалгаа	
Хавсралт 7	Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдэд хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү хандив өгсөн иргэдийн жагсаалт	
Хавсралт 8	Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдэд иргэнээс 1 сая, хуулийн этгээдээс 2 сая түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн жагсаалт	
Хавсралт 9	Нэр дэвшигчид хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг зарцуулсан жагсаалт	
Хавсралт 10	Нам иргэнээс хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг зарцуулсан жагсаалт	

**Аудит хийх  
үндэслэл, бүрэн эрх**

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл**

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, АНСДИТХСТ хуулийн 57 дугаар зүйл, Үндэсний аудитын газрын 2020 онд хийх аудитын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлээ.

**Аудитын зорилт**

АНСДИТХ-ын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслээс болон бие даан нэр дэвшигчдийн төвлөрүүлсэн орлого, иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, сонгуулийн зардлыг хянаж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, нийтэд мэдээлнэ.

**Аудитын хамарсан хүрээ**

Аудитад аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслээс болон бие дааж нэр дэвшигчдийн аудитын дүгнэлт, аудитын дэлгэрэнгүй тайлан, аудит хийгдсэн сонгуулийн зардлын тайлангийн маягтууд, харилцагч банкны дансны хуулга бусад шаардлагатай баримтуудыг хамарсан.

**Аудитын арга зүй,  
шалгуур үзүүлэлт**

Аудитын ажлыг гүйцэтгэхэд аймгийн дарга, тэргүүлэх аудиторын 2020 оны А/43 дугаар тушаалаар баталсан “Сонгуулийн зардлыг тайлагнах заавар, аргачлал”-ыг үндэслэн нэр дэвшигчдийн өөрийн хөрөнгө, нам, эвслээс оруулсан хөрөнгө, иргэн, хуулийн этгээдээс авсан хандив түүний зарцуулалтын тайланг шалгаж, аудит хийсэн хуулийн этгээд, нам, эвсэл, нэр дэвшигчдээс лавлагаа, тодруулга авч, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж тайланг бэлтгэв.

**Аудитын  
бүрэлдэхүүн,  
хугацаа**

**Аудитыг гүйцэтгэсэн хугацаа:**

Аудитыг 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд хэрэгжүүлж, дүнг нийтэд мэдээллээ.

**Аудитыг гүйцэтгэсэн багийн бүрэлдэхүүн:**

Аудитыг дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Намчинсүрэн, П.Мөнхтуяа, П.Содном, аудитор З.Ганбаатар, А.Сувдаа, Д.Даариймаа, Г.Цэрэнлхам нар гүйцэтгэлээ.

**Хүндрэл бэрхшээл**

Коронавируст халдвар / КОВИД-19 / цар тахлын үед бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан хуулийн хугацаанд аудитын дүгнэлт, хавсралт маягтууд, анхан шатны баримтыг эх хувиар нь хүлээн авах боломжгүй байдал үүссэн учир цахим хэлбэрээр хувийн аудитын компаниар гаргуулсан дүгнэлтийг хүлээн авсан.

**Бүлэг 1** Аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуулийн зардлын дансны мэдээллийг 1 нам, 28 нэр дэвшигч, сонгуулийн зардлын тайланг МАХН-ын аймгийн 1, сумын 5, МАН-ын сумын 7, АН-ын сумын 15 нам болон 108 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй байна.

1.1. Аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуулийн аймгийн 21 тойрог, сумын 75 тойрогт 3 намаас болон бие даагч нийт 802 нэр дэвшигч сонгуульд оролцсон байна.

*Аймаг, сумын ИТХ-ын ээлжит сонгуульд оролцохоор  
бүртгүүлсэн нам, нэр дэвшигчийн тоо*

*Хүснэгт №1*

Д/д	НАМЫН НЭР	НАМЫН ТОО		НЭР ДЭВШИГЧИД	
		Аймгийн ИТХ	Сумын ИТХ	Аймгийн ИТХ	Сумын ИТХ
1	Монгол Ардын нам	1	16	33	340
2	Ардчилсан нам	1	16	33	333
3	МАХН	1	5	11	40
4	Бие даан нэр дэвшигч			6	6
Нийт дүн		3	37	83	713

АНСДИТХСТ хуулийн 50 дугаар зүйлийн 50.3-д “ Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй” гэж заасны дагуу дансны дугаар, банкны нэрийг аймгийн 2, сумдын 32 нам, 774 нэр дэвшигч бүртгүүлсэн, 1 нам, 28 нэр дэвшигч сонгуулийн зардлын дансаа аймгийн төрийн аудитын байгууллагад бүртгүүлээгүй байна. /Хавсралт-3, 4/

АНСДИТХСТ хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-т “Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу сонгуулийн зардлын тайлангаа аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ТАГ-т хугацаандаа аймгийн 2 нам, сумын 694 нэр дэвшигч ирүүлсэн.

Сонгуулийн зардлын тайлангаа 50 нэр дэвшигч хугацаа хоцроож ирүүлсэн, сонгуулийн зардлын тайланг МАХН-ын аймгийн 1, сумын 5 нам, МАН-ын сумын 7, АН-ын сумын 15 нам болон 108 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй байна. /Хавсралт-3, 4/

**Бүлэг 2** Хуулиар зөвшөөрөгдөөгүй 9973.5 мянган төгрөгийг хандивыг 41 нэр дэвшигч, 8.0 сая төгрөгийн хандивыг нам зарцуулсан байна.

2.1. Нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлангаар нийт 335414.8 мянган төгрөгийн мөнгөн, 6439.0 мянган төгрөгийн мөнгөн бус мянган мөнгөн бус хандив байна.



## Намын сонгуулийн зардлын санхүүжилт

Хүснэгт №2

Д/д	Орлогын төрөл	Орлого /мян.төгрөг/				Нийт	
		Тоо	Мөнгөн	Тоо	Мөнгөн бус	Тоо	Дүн
1	Нам, эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө	2	111063.36	-	-	2	111063.36
2	Хуулийн этгээдийн хандив	1	10,000.0	-	-	1	10,000.0
3	Иргэний хандив	3	11,042.4	-	-	3	11,042.4
	Дүн	6	132105.7	0	0.0	6	132105.7

## Нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт

Хүснэгт №3

Д/д	Орлогын төрөл	Орлого /мян.төгрөг/				Нийт	
		Тоо	Мөнгөн	Тоо	Мөнгөн бус	Тоо	Дүн
1	Нам, эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө	39	48,001.0			39	48,001.0
2	Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө	225	19,838.0			225	19,838.03
3	Хуулийн этгээдийн хандив	12	15,290.0	1	681	13	15,971.0
4	Иргэний хандив	858	125250.2	7	5759	865	131009.2
	Нийт дүн	1104	203,309.1	41	6,439.0	1145	214819.0

## 2.2.Хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү хандив өгсөн хоёр иргэн байна.

АНСДИТХСТ хуулийн 53 дугаар зүйлийн 53.1-т “Мөнгөн хандив иргэний хувьд хоёр сая төгрөг хүртэл, хуулийн этгээдийн хувьд 10 сая төгрөг хүртэл байна”, 53.7-д “Бэлэн мөнгөөр хандив өгөх, авахыг хориглоно” гэж заажээ.

2020 оны аймаг, сумын ИТХ-ын ээлжит сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн 7 иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн 2 хуулийн этгээд байна. /Хавсралт-5/

Иргэн, хуулийн этгээдийн өгсөн хандивыг сонгуулийн зардлын тайлан, дансны хуулгатай тулган шалгахад хуулийн дээрх заалтын дагуу зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү хандив өгсөн 2 иргэний 9.0 сая төгрөгийн хандивыг буцаан шилжүүлээгүй зарцуулсан 1 нам, 1 нэр дэвшигч, бэлэн мөнгөөр хандив өгсөн иргэн, аж ахуйн нэгж байхгүй байна. /Хавсралт-6/

2.3. АНСДИТХСТ хуулийн дагуу аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуульд намууд сонгуулийн үйл ажиллагааны зардалд нийт 131233.7 мянган төгрөг зарцуулснаас сонгуулийн зардалд 131188.4 мянган төгрөг, бусад зардалд 45.3 мянган төгрөг, нэр



дэвшигчид сонгуулийн зардалд 209178.0 мянган төгрөг, бусад зардалд 12065.0 мянган төгрөг нийт 340411.7 мянган төгрөгийг зарцуулжээ.

### Намын сонгуулийн зардлын ангилал

Д/д	Зардлын ангилал		Хүснэгт№4 Мөнгөн дүн /мян.төг/
	Нийт зардлын дүн		
1	2.1	Сонгуулийн зардлын дүн	131188.4
2	2.1.1	Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах	64077.0
3	2.1.4	сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал	43,000.0
4	2.1.5	сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал	21111.4
5	2.1.6	сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал	3,000.0
6	2.2	Бусад зардлын дүн	45.3
	3	Төлөгдөөгүй байгаа өр төлбөр	4,500.0

### Нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын ангилал

Д/д	Зардлын ангилал		Хүснэгт№5 Мөнгөн дүн /мян.төг/
	2.Нийт зардлын дүн		
1	2.1	Сонгуулийн зардлын дүн	197113.1
2	2.1.1	Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах	58,598.2
3	2.1.2	Нийтийн эзэмшлийн гудамж талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах	537.0
4	2.1.3	намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал	2,850.0
5	2.1.4	сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал	4,233.7
6	2.1.5	сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал	125,364.0
7	2.1.6	сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал	264.4
8	2.1.7	цахим орчин ашиглах зардал	755.8
9	2.1.8	өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал	4510.0
10	2.2	Бусад зардлын дүн	12065.0
11	3	Төлөгдөөгүй байгаа өр төлбөр	1638.9

Нам, нэр дэвшигчдийн зардлын тайланд сурталчилгааны материал хэвлүүлэх зардал, хувь хүний орлогын албан татварын өглөг, хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг буцаан олгох зэрэг нийт 6138.9 мянган төгрөгийн өр төлбөр тайлагнасан байна.

**2.4. Булган аймаг дахь Төрийн аудитын газраас тогтоосон зардлын дээд хэмжээг баримталж ажиллажээ.**

АНСДИТХСТ хуулийн 49.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын газраас орон нутгийн сонгуульд нам, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоосон бөгөөд намын зарцуулсан зардлын дээд хэмжээ 119.2, нэр дэвшигчийн зарцуулсан зардлын дээд хэмжээ 5.8 сая төгрөг байна.

**Нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын хэмжээ**

Хүснэгт №6  
/сая.төг/

№	Нэр	Аймгийн ИТХ		Сумын ИТХ	
		ТАГ-аас тогтоосон дээд хэмжээ	Зарцуулсан зардлын хэмжээ	ТАГ-аас тогтоосон дээд хэмжээ	Зарцуулсан хэмжээ
1	Нам	364.6	0.9-119.2	15.7-32.6	0
2	Нэр дэвшигч	10.8-28.2	0-11.0	5.3-16.2	0-5.8

**2.5. Нам, нэр дэвшигчид хуулиар зөвшөөрөгдөөгүй 20.0 сая төгрөгийн хандивыг буцаан шилжүүлээгүй сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан байна.**

АНСДИТХСТ хуулийн 53 дуг53 дугаар зүйлийн 53.4-т "...Хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээд нь нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээллээ банкны гүйлгээний баримтад тусгах бөгөөд энэ шаардлагыг хангаагүй хандивыг хандив хүлээн авагч буцаан шилжүүлнэ", 53.5-д "Буцах хаяг нь тодорхойгүй хандивыг холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын орлогод буюу төрийн санд шилжүүлнэ" гэж тус тус заасан байна.

Хуульд заасны дагуу банкны гүйлгээний баримтад холбогдох мэдээллээ бүрэн тусгаагүй 98 иргэний хандив байснаас 18 иргэний 4609.9 мянган төгрөгийн хандивыг буцаан шилжүүлсэн байна. Харин 80 иргэний 9913.5 мянган төгрөгийн хуулийн этгээдийн хандивыг буцаан шилжүүлээгүй, сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулжээ. /Хавсралт-9/

Дээрх нэр дэвшигчдийн зөрчлийг аудитаар тогтоосон материаллаг түвшинтэй харьцуулан тогтоосон түвшинд хүрээгүй тул ХАК зөрчилгүй дүгнэлт гаргасан байна.

## ДҮГНЭЛТ

Аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланд хийсэн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

- Аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуулийн аймгийн 21 тойрог, сумын 75 тойрогт 3 намаас болон бие даагч нийт 802 нэр дэвшигч сонгуульд оролцсон байна.
- Дансны дугаар, банкны нэрийг 1 нам, 28 нэр дэвшигч сонгуулийн зардлын дансаа аймгийн төрийн аудитын байгууллагад бүртгүүлээгүй байна.

- Аймаг сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдээс сонгуулийн зардлын тайлангаа хувийн аудитаар баталгаажуулан хугацаа хоцроож ирүүлсэн 50 нэр дэвшигч, сонгуулийн зардлын тайланг МАХН-ын аймгийн 1, сумын-5 нам, МАН-ын сумын 7, АН-ын сумын 15 нам болон 110 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй байна.
- Хандивын эх үүсвэр, хандив өгсөн иргэний нэр, регистрийн дугаар тодорхойгүй 80 иргэнээс өгсөн 9913.5 мянган төгрөг, мөн хуульд заасан хандивын дээд хэмжээнээс илүү хандив өгсөн 2 иргэний 9000.0 мянган төгрөгийг хууль, журмын дагуу буцаан төвлөрүүлэлгүй зарцуулсан байна.

Аудитаар илэрсэн зөрчлийг АНСДИТХСТ хууль зөрчсөн нам, нэр дэвшигчдэд Зөрчлийн тухай хуульд заасан арга хэмжээг авч шийдвэрлүүлэх саналыг аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс, Татварын хэлтэст хүргүүллээ.